



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018. 02.05 № 09

Асуулга тавих тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдэд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржид арилжина" гэж заасан байгаа. Үүний дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, хувьцааг аж ахуйн нэгжид худалдах ажлыг зохион байгуулах тухай УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоол, 2011 оны 57 дугаар тогтоол, эдгээр тогтоолыг хэрэгжүүлэх Засгийн газрын 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тогтоол, 2012 оны 4 сарын 11-ний өдрийн 116 дугаар тогтоол, 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 181 дүгээр тогтоол тус тус гарсан билээ.

Эдгээр тогтоолын дагуу авсан арга хэмжээний үр дүнд Монгол Улсын иргэн бүр Таван толгойн орд газрын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Эрдэнэс-Таван толгой ХК-ийн 1072 хувьцааны эзэмшигч болсон. Одоо Ашигт малтмалын тухай хуулийн 5.6 дугаар заалт, УИХ, Засгийн газрын холбогдох тогтоолуудыг бүрэн хэрэгжүүлж, төрийн өмчит тухайн аж ахуйн нэгжийн хувьцааг дотоодын хөрөнгийн биржид арилжих боломжийг нээх цаг хугацаа нь болсон гэж үзэж байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК 2017 оны хагас жилийн байдлаар 255.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Эдийн засгийн байдал хүндрэлтэй энэ үед 1072 хувьцааны ногдол ашгийг иргэдэд хуваарилах, хувьцааг хөрөнгийн биржид бүртгүүлж, зах зээлийн эргэлтэд оруулж иргэдийг хөрөнгөжүүлэх нь богино болон урт хугацааны нийгэм эдийн засгийн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Энэхүү асуудалтай холбогдуулан Танд дараах асуулгыг тавьж байна.

Нэг. Эрдэнэс-Таван толгой ХК-ийн хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид бүртгүүлэн нээлттэй арилжих Засгийн газрын тогтоолыг энэ онд багтаан хэрэгжүүлэх төлөвлөгөө, бэлтгэл ажлын талаар;


Хоёр. Эрдэнэс-Таван толгой ХК-ийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуваарилах боломж бололцооны талаар эдгээр болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонгохыг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын хэрэг эрхлэх газарт

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.БАТБОЛД